



Ц.Жигмэд
МУБИС-ийн БС-ийн СӨБСС-ийн Сурган хүмүүжүүлэх,
сэтгэл судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D)

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ – ТУРШЛАГА

Үргэлжлэл

(Эхний хэсэг “Лавай” эрдэм шинжилгээний бичгийн 2014 оны 11 –р дугаарт хэвлэгдсэн)

Суралцагчийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжлэг өгөх, хамтран ажиллах талаар сургуулийн хэмжээнд зохион байгуулдаг олон талт ажлыг, гарсан үр дүнтэй нь хамт бичнэ, тухайлбал, “...оюутныг дагуулан сургах, хөгжүүлэх зорилгоор 2010-2011, 2011-2012 оны хичээлийн жилд Монгол бичгийн дугуйланг хичээллүүлсний үр дүнд “Үндэсний бичиг соёл” улсын 5-р уралдаанд 1-р курсийн оюутан Б.Бадамтуяа оролцож тусгай байрын шагнал (УБ 2010), 6-р уралдаанд 1-р курсийн оюутан Цэцэгмаа, Алтантуяа нар оролцсон (УБ.,2011), “СӨБ-ын менежментийн өдөрлөг”, МЭТХАЗ, ХЯХАЗ хичээлээр “Бага олимпиад” зэрэг арга хэмжээг 2008-2009 хичээлийн жилээс эхлэн жил бүр уламжлал болгон зохион явууллаа. Үүний үр дүнд оюутны мэргэжлийн сонирхол өсөж, мэргэжилдээ дур сонирхолтой болох, өөрийн бодол санаагаа илэрхийлэх чадварт эергээр нөлөөлсөн” гэж бичсэн байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг багш, оюутны оролцоотой боловсруулах талаар “... сургууль үйл ажиллагаа хөтлөн явуулах эрх зүйн орчноо “Боловсролын тухай” багц хууль, “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хууль, “Сургуулийн өмнөх насны хүүхдийн багш” -ийн стандарт, “Багшийн ажлын байрны тодорхойлолт”, “Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт” зэрэг боловсролын салбарт мөрдөж буй эрх зүйн баримт бичигт нийцүүлэн багш, оюутны оролцоотой боловсруулдаг”, «... Сургуулийн үйл ажиллагааг хөтлөн явуулах эрх зүйн баримт бичиг боловсруулахад хамт олон дараах байдлаар оролцдог. Үүнд:

1. МУБИС-ийн захирлын зөвлөл болон СӨБС-ийн СЭШ-ний зөвлөлөөс санаачлан боловсруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичигт саналаа тусгаж өгөх

2. Хамт олноороо хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр боловсруулсан баримт бичгийг шат дараалан хэлэлцүүлэх” гэж тайланд тусгаад одоогийн мөрдөж буй эрх зүйн 48 журам, дүрэм зэрэг эрх зүйн баримт бичгийн онцлогоос тайлбарласан.

Багшлах чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлж ажилласан байдлыг тайлангийн хугацаанд хэдэн багш ямар журмаар сонгон шалгаруулж авсныг “...Тайлангийн хугацаанд их сургуулийн багш байх шаардлагыг хангасан 11 багшийг шалгаруулж авч ажиллуулсан” гээд хүснэгтээр харуулж өгсөн байна. Шинээр авсан багшийн судалгаа

	2008-2009	2009-2010	2010-2011	2011-2012	2012-2013	Бүгд
Тоо	1	3	2	3	2	11

Багшийн чанарын байдлыг олон талын судалгаанд тулгуурлан гаргана.

Тухайлбал, “...Өнөөгийн байдлаар 10 багш докторантын сургалтад хамрагдаж байгаа нь магистр багш нарын 37%-ийг эзэлж байна. 2008 оноос хойш тус сургуулийн багш нараас 5 багш докторын зэрэг хамгаалж, үндсэн багшийн доктор, профессорын эзлэх хувь 25%-д хүрсэн байна” гэжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшийн бүрэлдэхүүний чанарыг тодорхойлж бичихдээ “...тус сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь мэргэжлийн боловсрол эзэмшсэн, нийт багшийн 74% нь 10 болон түүнээс дээш хугацаагаар тогтвор суурьшилтай ажилласан туршлагатай, эрдмийн зэрэг цолтой байгаагийн зэрэгцээ жил тутам докторантурт 2-3 багш элсэн суралцаж байгаа байдлаас дүгнэж үзэхэд профессор багш нарын бүрэлдэхүүний чанар хангалттай гэж үзэж байна” гээд үндсэн

багш нарын бүрэлдэхүүнээс гадна бакалаврын болон магистрын сургалтад нөөц эрдэмтэн, судлаачид хамтран ажилладаг талаар бичнэ.

Ажлын эерэг, бүтээлч уур амьсгал төлөвшүүлэх багш, ажилчдынхаа мэдлэг, туршлагыг хөтөлбөрийнхөө хөгжилд бүрэн ашигладаг талаар бичихдээ суралцагчдын хэрэгцээ сонирхолд нийцсэн тодорхой удирдамжийн дагуу хийгдсэн бүтээлийн үзэсгэлэн, тайлан тоглолт, хөгжүүлэх болон сургалтын идэвхтэй аргуудтай холбогдол бүхий ажлууд зэрэг багш нарын сургалтын арга, технологийг бичнэ. Өөрөөр хэлбэл, оюутныг идэвхжүүлэх, урамшуулах, мэргэжилд нь дур сонирхолтой болгохоор хийсэн, хэвшсэн ажлыг багцална.

	Хийгдсэн ажил	Үр дүн
Ерөнхий эрдмийн тэнхим	“Русский чай” Ногоон төгөл” арга хэмжээ	Дөнгөж элсэн орж буй оюутанд сургуультайгаа танилцах, сургуульдаа дасах, орос хэлний мэдлэгийг өргөжүүлэх, оросын соёл ахуйтай танилцдаг. Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ойлгож мэдрэх, орчны байгалиа хамгаалах, мод зүлэг арчилж сурах арга барил эзэмших.
Сурган,сэтгэл судлалын тэнхим	Сурган хүмүүжүүлэх олимпиад	Танхимд СХУ-ны хичээлээр олж авсан мэдлэгээ бататгах, практикт хэрэглэх, өөрийгөө илэрхийлэх чадварт суралцдаг
Аргазүйн тэнхим	Менежмент өдөрлөг	Удирдахуйн ухааны талаар олж авсан мэдлэгээ нийт оюутанд харуулдаг
Урлаг, спортын тэнхим	Урлагийн тайлан тоглолт Бүтээлийн үзэсгэлэн	Оюутан онолын мэдлэгээ практик үйл ажиллагаагаар харуулдаг

Мэргэжлийн ба мэргэших хичээлийн багш нар нь зааж буй хичээлийнхээ чиглэлээр мэдлэг, чадварыг бүрэн эзэмшсэн, мэргэжлийн бөгөөд мэргэжлээрээ зэрэгтэй, сургуулийн үндсэн багш байх талаар бичихдээ багш нарын үндсэн мэргэжил боловсрол, бусад чиглэлээр мэргэшсэн байдал, мэргэжлээ дээшлүүлсэн байдал, гадаад, дотоодод улс орны эрдэм шинжилгээний хуралд оролцож илтгэл тавьсан зэрэг мэдээлэл, багш нарын чадварыг тодорхой бичнэ. Тухайлбал,

... Сургуулийн нийт 41 багшаас 19 багш нь сургуулийн өмнөх насны хүүхдийн багшийн мэргэжилтэй байгаа бөгөөд 9 багш тус сургуульд 20-иос дээш жил ажилласан мэргэшсэн багш, 5 залуу багш байгалийн ухаан, биологи, дүрслэх урлагийн чиглэлээр мэргэшиж байна. Зах зээлийн нийгмийн энэ цаг үед улсаас сургуулийн өмнөх боловсролын багш чиглэлээр их, дээд сургуулийн багш бэлтгэх асуудал байхгүй байгаа ч тус сургууль оюуны өндөр чадавхтай залуу багш нарыг СӨБ-ын багш мэргэжлээр хөрвүүлэх, дээд сургуулийн багшлах эрхийн сургалтад хамруулах, ахмад туршлагатай багш нарыг дагалдуулан сургах талаар тайлангийн хугацаанд идэвхтэй ажиллаж бүх багшийн 87,5%-ийг сургуулийн өмнөх боловсролын багшийн мэргэжилтэй болгож чадсан юм” гэсэн байна.

Профессор-багш нарт шаардлага тавигдах шаардлага ямар байдаг, багш ажилд авах процессын тухай болон тухайн сургуулийн профессор- багш нарын их сургуулийн багшид тавигдах шаардлага хангаж байгаа байдал зэргийг дэлгэрэнгүй тодорхойлон гаргана. Тухайлбал, “... Тус сургуулийн багш нарын боловсролын зэргийг авч үзэхэд 24% доктор, 76% магистр бөгөөд бакалаврын зэрэгтэй багш байхгүй, профессор, дэд профессор, ахлах багш зэрэг эрдмийн цолтой багш 47% байгаа нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх боловсон хүчний хангалттай нөөц юм” гэжээ.

Багшийн цагийн ачааллыг “МУБИС-ийн профессор багш нарын ажлын «норм, түүнийг тооцох журам»-ын хүрээнд сургалт, эрдэм шинжилгээ, аргазүй чиглэлээр салган тайлбарлаж өгнө. Тухайлбал,

Багшийн жилийн ажлын нийт гүйцэтгэх цагийн ачаалал жилд 1680 цаг ба сургалт, эрдэм шинжилгээ, аргазүйн ажил гүйцэтгэнэ. Сүүлийн жилүүдэд багшийн гүйцэтгэх илүү цагийг нормт цагаас 50%-иас хэтрүүлэхгүй байхаар журамласан нь багшид өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, суралцагчидтай ажиллах цаг гаргах нөхцөлийг бүрдүүлж өгсөн” гээд багш нарын цагийн ачааллын тооцоог сүүлийн 3-4 жилээр гарган үнэлэлт дүгнэлт өгнө.

Сургалтын арга, технологийн шинэчлэлийг суралцагчдын хэрэгцээ сонирхолд нийцүүлэн оновчтой боловсруулан хэрэгжүүлэх ажлыг тодорхой үе шаттайгаар хийсэн, хөгжүүлэх сургалтын орчин үеийн арга технологиос суралцсан, багш бүхэн нээлттэй ба үзүүлэх хичээл хийж арга туршлагаа харилцан солилцсон, оюутнуудад чиглэсэн лекц, ярилцлага, хэлэлцүүлэг явуулах, сурах, сургах үйл ажиллагааг бодитой үнэлэх, суралцагчдын дэвшин суралцах сургалтын үйл явцыг удирдах, зохицуулах, хянах зэрэг ажлуудыг бичнэ. Тайлангийн хугацаанд суралцагчдаар бие даан уншиж



судлах, товчлол тэмдэглэл хийх, төлөвлөх, бичиж боловсруулах, зохион бүтээх, турших, илтгэх, хэлэлцэх, мэтгэлцэх, судлах, шинжлэх, туршлага судлах, сурвалжлах, дадлагажих, бодох, тооцоолох, сорил ажиллах, мэдээлэл харилцааны технологи ашиглах, асуудал шийдвэрлэх, үнэлгээ хийх, санал зөвлөмж гаргах, орчуулах зэрэг олон талт ажлыг сургалтын заах арга, технологийн чиглэлээр хийсэн гол ажилд оруулан бичигдсэн. Мөн багш нарын мэргэжил боловсролоо дээшлүүлсэн байдлыг багш бүрээр гарган бичиж тэнхим, сургуулийн хэмжээнд нэгтгэж өгнө.Тухайлбал:

	Тэнхим	Багшийн тоо	Гадаадад	Дотоодод
1	Сурган, сэтгэл судлалын тэнхим	11	63,6%	81,1 %
2	Заах арга зүйн тэнхим	10	33,3 %	70%
3	Ерөнхий эрдмийн тэнхим	9	44%	66,6 %
4	Урлаг спортын тэнхим	11	27,2%	72,7%
	Бүгд	41	41,4 %	75,6%

Багшийн өөрийн үйл ажиллагаандаа үнэлгээ өгөх асуудлыг оюутны хийсэн ажлаар үзэсгэлэн гаргасан байдал, мөн оюутны дунд олон төрлийн ажил зохион байгуулж үр дүнд нь анализ хийж өөрийн үнэлгээ хэрхэн хийдэг талаар дэлгэрэнгүй бичнэ.

Багшийн үнэлгээнд оюутны сэтгэл ханамжийн судалгааны сүүлийн 5 жилийн үнэлгээг багш бүрээр бичнэ. Тухайлбал, "... Сургуулийн хэмжээгээр жил бүр авбал зохих онооны 80 гаруй %-ийг авдаг бөгөөд жилийн «дундаж өсөлт, бууралт 5% орчим хувийн хэлбэлзэлтэй байдаг” гэж бичсэнээс гадна заадаг хичээл нь оюутны хэрэгцээ сонирхолд нийцдэг, багшийн харилцааны соёл, үлгэрлэл, хичээлийн цаг ашиглалт, явцын болон улирлын шалгалтыг төлөвлөсөн хугацаандаа чанартай авч бодитой үнэлдэг, багшийн оюутанд тусалдаг байдал, багшийн хичээл заах үр чадвар зэрэг асуудлаар жишээ баримттай бичнэ.

Багшийг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар бичихдээ багшийн эрдэм судлалын ажил, түүний нормчлол, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлд нийцүүлэн өөрийн сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар дэлгэрэнгүй дурдсан. Тухайлбал, "...Сургуулийн Өмнөх Боловсролын Сургуулийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл нь "Бага насны хүүхдийн цогц хөгжил", "Сургуулийн өмнөх боловсролын агуулга аргазүйн шинэчлэл" гэж байдаг бөгөөд тайлангийн хугацаанд эрдэм судлалын тэргүүлэх чиглэлийг "Багшийн хөгжлийн чиг хандлага", " Суралцагчдын хөгжил төлөвшлийн судалгаа " гэсэн агуулгаар баяжуулсан" гэжээ. Тайлангийн хугацаанд тэргүүлэх чиглэлийг агуулсан нэг сэдэвт зохиол бичиж байгаа багш нарт туслан дэмжиж ажилласан үр дүнг бичсэн. Тухайлбал, "...тайлангийн хугацаанд 5 багш боловсрол судлалын, 1 багш сэтгэл судлалын докторын (Ph.D) зэрэг горилсон нэг сэдэвт зохиолыг бичиж хамгаалсан" гээд багш бүрийн хамгаалсан сэдэв зэрэг мэдээллийг дэлгэрэнгүй бичдэг. Мөн багш нараас үндэсний хэмжээнд зохион байгуулсан судалгаа, туршилтын ажил, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл зэргийн бодит үйл ажиллагааг баримтаар бичиж хүснэгтээр харуулсан байна. Тухайлбал,

- Зургаан настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал /2008/
- Таван настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал /2009/
- Ахлах бүлгийн сургалтын хөтөлбөр /2012/
- Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт /2011/
- Бага насны хүүхдийн хөгжлийн стандартын зөвлөмж /2012/

Тайлангийн хугацаанд хийсэн багш нарын бүтээлийн товчоо.

№	Бүтээлийн хэлбэр	Тоо
1	Ном, сурах бичиг	17
2	Нэг сэдэвт зохиол	5
3	Бичиж нийтүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл	58
4	Сурган хүмүүжүүлэх уншлагад тавьсан илтгэл	42
5	Сургалтын хөтөлбөр, стандарт	95
6	Зөвлөмж, гарын авлага, удирдамж, тайлан	251
7	Орчуулга	38

Багш нарын хамтач үйл ажиллагааг хөтөлбөр боловсруулсан, ном, гарын авлага бичсэн, хичээлээс гадуурх ажил, сургалт-семинар явуулсан талаар үр дүнтэй нь хамт бичнэ. Мөн хамтарсан бүтээлийн жагсаалт байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын зүгээс оюутны сурах чадвар, чадамжийг хөгжүүлэхийн тулд хийсэн ажлыг эрдэм судлалын ажилд татан оролцуулж илтгэл бичүүлсэн, ангийн ажил хийлгэж судалгааны ажлын арга барилд сургасан, маргаан, мэтгэлцээн зохион байгуулж үзэл бодлоо илэрхийлж сургасан, хэлэлцүүлэг явуулж асуудлыг олон талаас нь авч үзэх, аливаа асуудлын мөн чанарыг таних арга барилд сургасан, ном, гарын авлага гаргаж бие даан суралцах нөхцөл бүрдүүлж өгсөн, дугуйлан, секц явуулж бие бялдраа хөгжүүлэх боломж олгосон зэрэг олон хэлбэрийн ажилд үндэслэн бичнэ.

Сургалтын хөтөлбөрийн удирдлагын талаар бичсэн өөрийн үнэлгээний тайлангийн SWOT шинжилгээний давуу талыг 17 үзүүлэлтээр тухайлбал, "...Өнөөгийн байдлаар 10 багш докторантын сургалтад хамрагдаж байгаа нь магистр багш нарын 37%-ийг эзэлж байна. 2008 оноос хойш тус сургуулийн багш нараас 5 багш докторын зэрэг хамгаалж үндсэн багшийн доктор, профессорын эзлэх хувь 25%-д хүрсэн байна", сул талыг 14 үзүүлэлтээр тухайлбал, "... Сургуулийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийн талаар судалгаа, шинжилгээний ажлыг бодлогоор дэмжих", боломжийг 13 үзүүлэлтээр тухайлбал, "...Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургууль үйл ажиллагаагаа хөтлөн явуулах эрх зүйн орчныгоо "Боловсролын тухай" багц хууль, "Сургуулийн өмнөх боловсролын тухай" хууль, "Сургуулийн өмнөх насны хүүхдийн багш"-ийн стандарт, "Багшийн ажлын байрны тодорхойлолт", "Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт" зэрэг боловсролын салбарт мөрдөж буй эрх зүйн баримт бичигт нийцүүлэн багш, оюутны оролцоотой боловсруулж мөрддөг", эрсдэлийг 8 үзүүлэлтээр тухайлбал, "...Суралцагчдын сургалтын төлбөрт ямар ямар зардлууд орж байгаа талаарх мэдээллийг хүргэх ажлыг боловсронгуй болгох" гэх мэтчилэн дүн шинжилгээ хийсэн юм.

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн ерөнхий дүгнэлтийг "...Бүлэг бүрийн дараах SWOT шинжилгээг нэгтгэн дүгнэж үзвэл "Багш, сургуулийн өмнөх насны хүүхдийн " бакалаврын зэрэг олгох энэхүү хөтөлбөр хоёр дахь удаагийн магадлан итгэмжлэгдэх шаардлагыг хангасан байна гэж бид үзлээ" гэж томъёолжээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Боловсрол Шинжлэх Ухааны Яам. (2012). *Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл*. Улаанбаатар

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, БХХ, ДБМИҮЗ. (1999). *Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны тухай*. Улаанбаатар

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, БХХ, ДБМИҮЗ. (2002). *Хөтөлбөрийн магадлан итгэмжлэх арга зүйн зөвлөмж*. Улаанбаатар

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Сургуулийн Өмнөх Боловсролын Сургуулийн. "Багш, сургуулийн өмнөх насны хүүхдийн" бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан

Редактор, Алзахгүй, М. (2004) БМИҮЗ. *Магадлан итгэмжлэл*. Улаанбаатар

Түмэндэмбэрэл, Д, ба бус. (2010). *Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл*. Улаанбаатар